

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын  
2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/16/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: А.Цогбаяр Утас: 261628 Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Ариунжаргал Утас:261740 Цахим хаяг: ariunjargalb@audit.gov.mn Аудитор: Д.Номингуа Утас:261740 Цахим хаяг: nominguad@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	<b>3</b>
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	<b>6</b>
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	<b>13</b>
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	15
3.4.1 Мөнгөн хөрөнгө .....	15
3.4.2 Авлага .....	16
3.4.3 Урьдчилгаа.....	17
3.4.4 Бараа материал.....	17
3.4.5 Үндсэн хөрөнгө.....	18
3.4.6 Өр төлбөр.....	19
3.4.7 Урьдчилж орсон орлого.....	20
3.4.8 Засгийн газрын хувь оролцоо .....	20
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	20
3.5.1 Төсвийн төлөвлөлт .....	20
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	21
3.5.3 Нэмэлт төсөв .....	21
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.....	22
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	<b>24</b>
4.1 Ерөнхий зүйл .....	24
4.2 Материаллаг байдал .....	24
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	24
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	24
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	25
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	27
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	<b>28</b>
5.1 Хүүхэд гэр бүл хөгжил, хамгааллын ерөнхий газрын харьяа байгууллагууд: .....	28
5.2.Төсвийн төвлөрүүлэн захирагч: .....	28
5.2.1. Албан шаардлага.....	28
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	<b>31</b>

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГБХНХС	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ГБХНХЯ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НҮТББ	Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага
ОУХНЦ	Олон улсын хүүхдийн найрамдал цогцолбор
ҮАГ	Үндэсний аудитын газар
САГ	Санхүүгийн аудитын газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХГБХХГ	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар
ХГБХХЕГ	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар
ХГБХХХ	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.25 № 800  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ,  
ХАМГААЛЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.БАЯРСАЙХАН ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагч болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 19,514.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

1. Зарим байгууллагуудын жилийн эцсийн хөрөнгийн тооллогын комисс нь нийт 10,680.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 397.5 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлд хуульд заасан хугацаанд тооллогыг хийгээгүй, тооцоо бодож баталгаажуулаагүй;
2. Тайлант онд нээлттэй тендер шалгаруулалтын аргыг ашиглан нийт 434.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төрлийн худалдан авах ажиллагааны тендерийн шалгаруулалтын баримт бичиг гүйцэтгэлийн баталгааны талаар тусгаагүй, баталгааг гаргуулаагүй, санхүүжилтийг бүрэн олгосон;
3. Анхан шатны баримтын бүрдэл дутуу, нотлох баримтын шаардлага хангаагүй нийт 333.3 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэсэн;

4. Хүүхэд харах үйлчилгээ, Асрамж халамжийн төв, Хүүхдийн зусланд үйлчилгээ авч байгаа хүүхдийн хувьсах зардлыг зарцуулахдаа тогтоосон нормативыг баримтлаагүй, зөрүүтэй тооцсон, батлагдсан төсөвгүй зарцуулсан нийт 251.3 сая төгрөг;
5. Санхүүгийн тайланд тусгасан олон жил болсон нийт 152.7 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй, тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, 62.0 сая төгрөгийн авлагыг шинээр үүсгэсэн зэрэг зөрчлүүд илэрсэн.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, 16.5.7, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 24 дүгээр зүйлийн 24.1, 44 дүгээр зүйлийн 44.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2, 72.4.1 дэх заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын “ангилал”, “нийцсэн ба зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Нэмэлт санхүүжилтээр төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 966.2 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгасан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 7,264.5 сая төгрөг, Засгийн газрын болон Засаг даргын нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 3,969.4 сая төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийн орлого 342.1 сая төгрөг, нийт 12,542.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, гүйцэтгэлээр 12,211.9 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 330.2 сая төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлжээ.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээний зардлын санхүүжилтэд нийт 20,366.2 сая төгрөгийг төлөвлөж, гүйцэтгэлээр 15,259.7 сая төгрөгийг аймаг, дүүргийн Хүүхэд гэр бүл, хөгжил хамгааллын газрууд олгож, 5,106.5 сая төгрөгийг зарцуулаагүй байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд Монгол Улсад сум, хороо бүрд хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан 833 нийгмийн ажилтны орон тоо бий болгосны үр дүнд далд хэлбэрийн хүчирхийллийг илрүүлэх, шийдвэрлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар сайжирч, хүчирхийллийн дуудлага мэдээлэл тодорхой хувиар буурч, кейс шийдвэрлэлт нь 83.6 хувьтай болж, өмнөх оны мөн үеэс 18.0 хувиар нэмэгджээ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		5,180,277.3	5,791,396.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	274,830.6	-
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	610,689.2	544,778.4
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	75,074.7	367,023.4
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	4,219,682.8	4,879,594.6
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		74,575,583.2	84,447,341.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	74,575,583.2	84,447,341.0
39200	Биет хөрөнгө		70,774,371.7	79,548,331.3
39300	Биет бус хөрөнгө	13	3,801,211.5	4,899,009.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		79,755,860.5	90,238,737.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		205,073.8	291,045.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	205,073.8	291,045.0
41300	Өглөг	17а, 17б	205,073.8	214,979.9
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	-	76,065.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		79,550,786.7	89,947,692.4
51	Засгийн газрын хувь оролцоо		79,550,786.7	89,947,692.4
51100	Засгийн газрын оруулсан капитал		22,235,381.5	21,530,790.1
51200	Хуримтлагдсан үр дүн		33,896,749.1	46,385,572.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		23,418,656.1	22,031,330.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		79,755,860.5	90,238,737.4

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		87,044,510.1	115,975,790.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	23,415,343.2	115,975,790.1
120	Нийтлэг татварын бус орлого		23,415,343.2	23,899,126.8
122	Тусламжийн орлого		-	92,086,782.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		63,629,166.9	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	71,659,450.7	103,061,309.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ		71,659,450.7	103,061,309.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		66,079,003.0	92,286,781.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		28,131,675.1	46,824,929.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		3,457,386.3	5,850,323.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		3,861,750.2	5,065,253.5
2104	Хангамж, бараа материалын зардал		2,390,034.3	3,089,365.4
2105	Нормативд зардал		3,945,113.1	5,632,388.6

**Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2106	Эд хогшил, урсгал засварын зардал		578,065.9	705,478.4
2107	Томилолт, зочны зардал		146,717.5	414,824.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		16,726,750.1	16,445,455.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		6,841,510.5	8,258,761.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		5,580,447.7	10,774,528.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		15,385,059.4	12,914,480.2
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		-	2,100.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		2,830,954.9	2,536,114.2
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		(2,830,954.9)	(2,534,014.2)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		12,554,104.5	10,380,466.0

**2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	70,766,908.1	99,594,779.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,623,901.2	99,594,779.2
120	Нийтлэг татварын бус орлого	6,623,901.2	7,139,495.4
122	Тусламжийн орлого	-	92,455,283.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	64,143,007.0	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	68,331,940.7	98,694,088.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	68,331,940.7	98,694,088.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	62,384,358.2	87,682,258.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	28,134,183.8	46,556,189.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,414,627.7	5,791,013.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,883,202.8	5,267,809.1
2104	Хангамж, бараа материалын зардал	1,101,158.2	1,704,581.8
2105	Нормативт зардал	3,997,249.7	5,887,624.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	938,081.0	728,487.4
2107	Томилолт, зочны зардал	131,587.8	382,978.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,404,614.1	18,232,416.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,379,653.2	3,131,157.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,947,582.5	11,011,830.4
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	9,736,568.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,238,474.6	1,165,002.9
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	110,258.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,434,967.4	900,690.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,263,169.8	1,175,521.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,263,169.8	1,175,521.0
2200	Дотоод эх үүсвэрээр	2,263,169.8	1,175,521.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(2,263,169.8)	(1,175,521.0)

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	171,797.6	(274,830.6)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	103,032.9	274,830.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	274,830.6	-

#### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны нэр төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>67,003,394.3</b>	-	<b>67,003,394.3</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	408,589.0	-	408,589.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	67,411,983.3	-	67,411,983.3
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(415,301.1)	-	(415,301.1)
Тайлант үеийн үр дүн	12,554,104.5	-	12,554,104.5
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>79,550,786.7</b>	-	<b>79,550,786.7</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,397,765.6	-	1,397,765.6
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	80,948,552.3	-	80,948,552.3
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(907,752.0)	-	(907,752.0)
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(373,264.6)	-	(373,264.6)
Тайлант үеийн үр дүн	10,280,156.7	-	10,280,156.7
<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>89,947,692.4</b>		<b>89,947,692.4</b>

## 2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Дансны нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	93,506,521,400.00	81,190,749,536.02	12,315,771,863.98	86.8
12	Татварын бус орлого	93,506,521,400.00	81,190,749,536.02	12,315,771,863.98	86.8
120	Нийтлэг татварын бус орлого	7,028,964,900.00	7,096,696,160.38	(67,731,260.38)	101.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	6,840,886,300.00	6,884,569,410.38	(43,683,110.38)	100.6
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	188,078,600.00	212,126,750.00	(24,048,150.00)	112.8
122	Тусламжийн орлого	86,477,556,500.00	74,094,053,375.64	12,383,503,124.36	85.7
122005	Төсвөөс санхүүжих	86,477,556,500.00	74,094,053,375.64	12,383,503,124.36	85.7
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	93,506,521,400.00	81,142,079,536.02	12,364,441,863.98	86.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	93,506,521,400.00	81,142,079,536.02	12,364,441,863.98	86.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	91,856,430,900.00	80,098,903,864.86	11,757,527,035.14	87.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	47,154,947,300.00	42,834,276,923.61	4,320,670,376.39	90.8
210101	Үндсэн цалин	24,813,739,400.00	23,833,816,049.71	979,923,350.29	96.1
210102	Нэмэгдэл	10,594,073,400.00	9,220,945,731.14	1,373,127,668.86	87.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,174,360,500.00	6,668,729,931.39	505,630,568.61	93.0
210104	Урамшуулал	4,572,774,000.00	3,110,785,211.37	1,461,988,788.63	68.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,895,601,200.00	5,344,304,928.31	551,296,271.69	90.6
210201	Тэтгэврийн даатгал	4,024,126,500.00	3,645,611,487.36	378,515,012.64	90.6
210202	Тэтгэмжийн даатгал	467,159,500.00	435,508,180.84	31,651,319.16	93.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	239,072,200.00	224,101,545.41	14,970,654.59	93.7
210204	Ажилгүйдлийн даатгал	233,030,900.00	207,012,652.61	26,018,247.39	88.8
210205	Эрүүл мэндийн даатгал	932,212,100.00	832,071,062.09	100,141,037.91	89.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,452,062,300.00	5,026,644,455.53	425,417,844.47	92.2
210301	Гэрэл, цахилгаан	989,364,200.00	781,630,049.34	207,734,150.66	79.0
210302	Түлш, халаалт	3,740,917,800.00	3,617,817,634.89	123,100,165.11	96.7
210303	Цэвэр, бохир ус	452,976,000.00	374,509,719.02	78,466,280.98	82.7
210304	Байрны түрээс	268,804,300.00	252,687,052.28	16,117,247.72	94.0
2104	Хангамж, бараа материалын зардал	2,445,577,900.00	1,508,969,755.09	936,608,144.91	61.7
210401	Бичиг хэрэг	612,805,800.00	307,486,489.97	305,319,310.03	50.2
210402	Тээвэр, шатахуун	846,211,500.00	581,612,622.80	264,598,877.20	68.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	287,553,000.00	152,089,469.53	135,463,530.47	52.9
210404	Ном, хэвлэл	244,290,800.00	119,499,762.00	124,791,038.00	48.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	107,086,600.00	43,851,141.76	63,235,458.24	40.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	347,630,200.00	304,430,269.03	43,199,930.97	87.6
2105	Нормативт зардал	6,500,751,300.00	5,508,165,216.95	992,586,083.05	84.7

**Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн  
нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	179,583,000.00	120,298,902.07	59,284,097.93	67.0
210502	Хоол, хүнс	4,985,603,200.00	4,404,765,605.88	580,837,594.12	88.3
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,335,565,100.00	983,100,709.00	352,464,391.00	73.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	783,846,900.00	666,923,284.00	116,923,616.00	85.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	111,485,500.00	98,537,500.00	12,948,000.00	88.4
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	69,617,000.00	33,026,650.00	36,590,350.00	47.4
210604	Урсгал засвар	602,744,400.00	535,359,134.00	67,385,266.00	88.8
2107	Томилолт, зочны зардал	552,832,900.00	315,320,240.00	237,512,660.00	57.0
210702	Дотоод албан томилолт	552,832,900.00	315,320,240.00	237,512,660.00	57.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,154,087,700.00	16,547,804,022.97	3,606,283,677.03	82.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,633,390,100.00	16,181,715,647.16	3,451,674,452.84	82.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	29,746,000.00	17,491,600.00	12,254,400.00	58.8
210803	Даатгалын үйлчилгээ	34,631,900.00	26,080,813.00	8,551,087.00	75.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	14,403,500.00	9,057,912.76	5,345,587.24	62.9
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	2,997,200.00	798,980.00	2,198,220.00	26.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	407,402,300.00	295,625,273.85	111,777,026.15	72.6
210807	Газрын төлбөр	30,531,700.00	16,905,696.20	13,626,003.80	55.4
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	985,000.00	128,100.00	856,900.00	13.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,916,723,400.00	2,346,495,038.40	570,228,361.60	80.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	504,053,300.00	288,875,574.00	215,177,726.00	57.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,412,670,100.00	2,057,619,464.40	355,050,635.60	85.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,650,090,500.00	1,043,175,671.16	606,914,828.84	63.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,650,090,500.00	1,043,175,671.16	606,914,828.84	63.2
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	187,616,000.00	66,095,000.00	121,521,000.00	35.2
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	512,484,900.00	448,807,146.18	63,677,753.82	87.6
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	52,549,700.00	49,333,299.98	3,216,400.02	93.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	897,439,900.00	478,940,225.00	418,499,675.00	53.4
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	48,670,000.00	(48,670,000.00)	-
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(48,670,000.00)	48,670,000.00	-

**Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(48,670,000.00)	48,670,000.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	36	36	-	100
610001	Төсвийн байгууллага	36	36	-	100
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	1,011	1,172	(161)	115.9
620001	Удирдах ажилтан	36	36	-	100
620002	Гүйцэтгэх ажилтан	733	815	(82)	111.2
620003	Үйлчлэх ажилтан	242	321	(79)	132.6

**2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Дансны нэр төрөл	Цэвэр дүн
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	12,589,996,732.42
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,589,996,732.42
122	Тусламжийн орлого	12,589,996,732.42
1221	Хандив тусламж /дотоод/	12,589,996,732.42
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,589,996,732.42
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, туслам	342,062,071.00
350013	Унаа хоолны хөнгөлөлт	3,969,426,506.29
350014	Урамшуулал	7,264,454,189.76
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,014,053,965.37
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,211,949,862.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,211,949,862.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,168,943,322.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,721,912,162.25
210101	Үндсэн цалин	1,508,470,278.33
210102	Нэмэгдэл	1,176,407,917.27
210103	Унаа хоолны хөнгөлөлт	459,333,333.41
210104	Урамшуулал	505,427,758.24
210105	Гэрээт ажлын хөлс	72,272,875.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	446,709,006.05
210201	Тэтгэврийн даатгал	328,061,405.01
210202	Тэтгэмжийн даатгал	30,373,002.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,006,123.86
210204	Ажилгүйдлийн даатгал	15,615,628.30
210205	Эрүүл мэндийн даатгал	55,652,846.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	241,164,639.04
210301	Гэрэл, цахилгаан	70,363,532.08
210302	Түлш, халаалт	124,041,859.90
210303	Цэвэр, бохир ус	26,319,247.06
210304	Байрны түрээс	20,440,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	212,083,493.77
210401	Бичиг хэрэг	45,266,606.00
210402	Тээвэр, шатахуун	44,879,610.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,127,616.77
210404	Ном, хэвлэл	500,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,048,920.00

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	100,260,741.00
2105	Нормативт зардал	373,808,853.99
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,555,684.07
210502	Хоол, хүнс	319,893,771.62
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	31,359,398.30
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	722,171,037.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	291,949,430.00
210602	Тавилга	24,631,600.00
210604	Урсгал засвар	405,590,007.00
2107	Томилолт, зочны зардал	67,657,815.00
210701	Гадаад албан томилолт	16,501,400.00
210702	Дотоод албан томилолт	51,156,415.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,525,652,321.65
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,510,484,213.65
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,883,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	449,110.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,158,802.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,667,700.00
210807	Газрын төлбөр	986,896.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	857,783,994.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	475,688,098.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	382,095,896.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,006,540.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,006,540.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	43,006,540.00
III	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	378,046,869.67
V	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(378,046,869.67)
VI	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(378,046,869.67)

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Тогтвортой, аз жаргалтай, ирээдүйд итгэлтэй хүүхэд, гэр бүлийг төлөвшүүлэх, хөгжүүлэх, тэдний эрхийг хамгаалахад оршино” гэж тодорхойлсон байна.

ХГБХХЕГ нь “Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын чиглэлээрх хууль, төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, гэр бүлийн боловсролыг дэмжих, хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээний нэр төрөл, чанарыг дээшлүүлэх, төрийн байгууллага, орон нутгийн нэгж, салбар байгууллагыг мэргэжил, арга зүй, удирдлагаар хангах” гэсэн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

ХГБХХЕГ нь үйл ажиллагааны эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхээр заасан байна. Үүнд:

- Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийг хүний эрхэд суурилсан хандлага, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэрэгцээнд нийцүүлж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;
- Нотолгоонд суурилсан төлөвлөлтийг хэрэгжүүлж, судалгаа шинжилгээ, дэвшилтэд технологи, инновацад тулгуурласан хүртээмжтэй үйлчилгээг нэвтрүүлэх;
- Гэр бүл төвтэй хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх, нийгмийн ажлын мэргэжлийн удирдлагыг хөгжүүлэх;
- Хүний нөөцийн ур чадварыг тогтмол дээшлүүлж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, мэдээлэл технологийн хурдацтай хөгжилд нийцсэн чадварлаг бүтцийг хөгжүүлэх, салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих;
- Чанар үр дүн, нотолгоонд суурилсан төлөвлөлт, төсөвлөлт, хяналтын үйл ажиллагааг сайжруулах.

Тайлант оны онцлог үйл явдлууд:

- Монгол Улсад Хүүхдийн байгууллага, хөдөлгөөн үүсэж, хөгжсөний 100 жилийн ой тайлант онд тохиож, Монгол Улсын Засгийн Газрын 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 143 дугаар тогтоолын дагуу тэмдэглэн өнгөрүүлжээ;
- ХГБХХЕГ-ын даргын 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/214 дүгээр тушаалын дагуу “ОНЫ ОНЦЛОХ ХҮҮХЭД” шалгаруулах арга хэмжээг хүүхдийн хөгжих, нийгмийн амьдралд оролцох, гаргасан амжилт, ололтыг алдаршуулах, үлгэр дуурайлал болгох зорилгоор “Оны онцлох хүүхэд”-ийг шалгаруулж, шагнал гардуулах ёслолыг 33 дахь жилдээ уламжлал болгон зохион байгуулж, шалгарсан 97 хүүхдийн шагналын зардалд 32.4 сая төгрөгийг зарцуулжээ.
- Нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөөг 21 аймаг, 9 дүүргийн газар, хэлтсийн дэргэдэх гэр бүлд зөвлөгөө өгөх 31 төв, танхимаар дамжуулан үзүүлж, тайлант онд 97,101 иргэн, үүнээс 55,233 насанд хүрэгч, 39,706 хүүхэд, 16,335 гэр бүлд зөвлөгөө өгч ажилласан;
- Гэр бүлийн боловсрол олгох 8 модуль 24 сэдвээр 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн хэмжээнд 671 “Сургагч багш”-ийг бэлтгэн 376,453 (давхардсан тоогоор) иргэнийг гэр бүлийн боловсрол олгох сургалтад хамруулсан;
- Байнгын асаргаа шаардлагатай хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг эцэг эх, асран хамгаалагчийн хамт “Оролцоод хөгжье” зуслангийн тусгай ээлжид 21 аймаг, 9 дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг зуслангийн үйлчилгээнд хамруулан ажилласан;
- “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэний хоногт хэрэглэх хоолны норм, илчлэгийн хэмжээ, зардлын норматив”-ын дагуу хувьсах зардалд нийт 9 асрамж, халамжийн төвийн 234 хүүхдэд 887.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

ХГБХХЕГ нь Төсвийн тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль, тогтоомж, дүрэм журмыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд төсвийн төвлөрүүлсэн захирагч болон санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд голлон мөрдөх дараах хууль, тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 дахь заалт;
- Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн “Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 52 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн “Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 04, 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” 05 дугаар албан даалгаврууд гаргасан;

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудит, мониторингийн газар нь Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын “Дотоод аудитын 2025 оны төлөвлөгөө батлах тухай” А/08 дугаар тушаалын удирдамж боловсруулан байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хэрэгжүүлэн, илэрсэн алдаа зөрчилд зөвлөмж өгч, хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ХГБХХЕГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.

ХГБХХЕГ болон харьяа байгууллагууд нь газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/02 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Монгол Улсын Сангийн Сайдын тушаалаар баталсан журам, заавар, аргачлалын шаардлагад нийцсэн боловч байгууллагын бүтэц, чиг үүрэг нэмэгдсэнтэй холбоотойгоор тус бодлогын баримт бичгийг салбарын үйл ажиллагааны онцлогт тохируулан шинэчлэх шаардлагатай байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Засгийн газрын 2024 оны “Төсвийн төвлөрүүлэн захирагчийг шинэчлэн батлах тухай” 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 110 дугаар тогтоолын хавсралтаар Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрыг төсвийн төвлөрүүлэн захирагч болгож, түүний харьяанд ХГБХХЕГ болон орон нутаг дахь Хүүхэд, гэр бүл хөгжлийн хамгааллын газар, Олон улсын найрамдал цогцолбор, Хүүхдийн төлөө сан, Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв, Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байр, Өнөр бүл хүүхдийн төв зэрэг байгууллагуудыг хамруулахаар баталжээ.

ХГБХХЕГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 90,238.7 сая төгрөг болж өмнөх оноос 10,482.8 сая төгрөгөөр буюу 13.1 хувиар нэмэгдсэн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	274,830.6	-	(274,830.6)
Авлага	610,689.2	544,778.4	(65,910.8)
Урьдчилгаа	75,074.7	367,023.4	291,948.6
Бараа материал	4,219,682.8	4,879,594.6	659,911.7
Үндсэн хөрөнгө	74,575,583.2	84,447,341.0	9,871,757.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>79,755,860.5</b>	<b>90,238,737.4</b>	<b>10,482,876.8</b>
Өглөг	205,073.8	214,979.9	9,906.1
Урьдчилж орсон орлого	-	76,065.1	76,065.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	79,550,786.7	89,947,692.4	10,396,905.7
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>79,755,860.5</b>	<b>90,238,737.4</b>	<b>10,482,876.8</b>

*Эх сурвалж: Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, урьдчилж орсон орлого, засгийн газрын хувь оролцоо данснууд байна. Тухайлбал:

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 274.8 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн сангийн харилцах	274,830.6	-	(274,830.6)
<b>Дүн</b>	<b>274,830.6</b>	<b>-</b>	<b>(274,830.6)</b>

*Эх сурвалж: Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Төрийн сан банкин дахь мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл нийт 274.8 сая төгрөгөөр буурч оны эцэст үлдэгдэлгүй гарсан нь харьяа байгууллагуудын Ахмадын сангийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна. /ОУХНЦ, Баян-Өлгий, Говьсүмбэр, Дархан-

Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Хэнтий аймаг дахь ХГБХХГ болон Нийслэлийн ХГБХХХ, ХГБХХЕГ/

**Аудитын илрүүлэлт:** Харьяа байгууллагуудад мөнгөн хөрөнгө данстай холбоотой нийт 3,829.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн.Тухайлбал:

- Хүүхэд, гэр бүлийн хөгжил оролцоог дэмжих үйл ажиллагааны хүрээнд нэг үүсвэрээс худалдан авах ажиллагааны аргыг хэрэглэн нэг хуулийн этгээдтэй нийт 535.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй QR бүхий, зурагтай наадаг стикерийг 997,000 ширхгийг гэрээний үнийн дүнгийн 41.9 хувь буюу 224.3 сая төгрөгөөр худалдан авсан, уг стикер нь бүрэн ашиглагдаагүй, ажил гүйцэтгэх гэрээний тусгай нөхцөлд баталгаат хугацаа 36 сар гэсэн байхад барьцааны хөрөнгийн талаар тусгаагүй, санхүүжилтийг бүрэн олгосон; /ХГБХХЕГ/
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу, нотлох баримтын шаардлага хангаагүй нийт 333.3 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэсэн нь санхүү, нягтлан бодох бүртгэлд тавих дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна. /ХГБХХЕГ 181.0 сая төгрөг, Чингэлтэй дүүргийн ХГБХХХ 143.4 сая төгрөг, Налайх дүүргийн ХГБХХХ 8.4 сая төгрөг, Орхон аймгийн ХГБХХГ 0.5 сая төгрөг/
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар даалгаврыг зөрчин хэвлэл мэдээллийн хэрэгсэл, телевиз, сайт, өдөр тутмын сонин зэрэг хэвлэл мэдээллийн 13 байгууллагатай 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдөр гэрээ байгуулан 64.3 сая төгрөгийг шилжүүлсэн, бараа материалын дансаар дамжуулаагүй 168.4 сая төгрөгийг материалыг шууд зардлаар тайлагнасан. /ХГБХХЕГ/
- Мөнгөн гүйлгээний тайланд зардлын ангиллыг нийт 57.1 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;/Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв 18.8 сая төгрөг, ХГБХХЕГ 16.7 сая төгрөг, Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байр 14.3 сая төгрөг, Хөвсгөл аймгийн ХГБХХГ 7.2 сая төгрөг/
- Ажилчдын цалин, урамшуулал, нэмэгдлийг илүү тооцож олгосон, нийгмийн даатгалын шимтгэл, татварыг зөрүүтэй суутгасан зэрэг нийт 413.3 сая төгрөг; /Нийслэлийн ХГБХХГ 252.4 сая төгрөг, Ховд аймгийн ХГБХХГ 93.0 сая төгрөг, Дорнод аймгийн ХГБХХГ 23.6 сая төгрөг, ХГБХХЕГ 14.8 сая төгрөг, Хөвсгөл аймгийн ХГБХХГ 6.6 сая төгрөг, Төв аймгийн ХГБХХГ 5.8 сая төгрөг, Завхан аймгийн ХГБХХГ 5.3 сая төгрөг, Хан-Уул дүүргийн ХГБХХХ 5.6 сая төгрөг, Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв 1.8 сая төгрөг, Багануур дүүргийн ХГБХХХ 1.4 сая төгрөг, Сонгинохайрхан дүүргийн ХГБХХХ 1.1 сая төгрөг, Архангай аймгийн ХГБХХГ 0.8 сая төгрөг, Говь-Алтай аймгийн ХГБХХГ 0.5 сая төгрөг, Өнөр бүл хүүхдийн төв 0.3 сая төгрөг, Дархан-Уул аймгийн ХГБХХГ 0.1 сая төгрөг/
- Хүүхэд харах үйлчилгээ, асрамж халамжийн төв, зусланд үйлчилгээ авч байгаа хүүхдийн хувьсах зардлыг зарцуулахдаа тогтоосон нормативыг баримтлан ажиллаагүй, зөрүүтэй тооцсон, батлагдсан төсөвгүй зарцуулсан зэрэг нийт 251.3 сая төгрөг; /Өнөр бүл хүүхдийн төв 206.8 сая төгрөг, Дундговь аймгийн ХГБХХГ 15.6 сая төгрөг, Баянгол дүүргийн ХГБХХХ 12.1 сая төгрөг, Баянзүрх дүүргийн ХГБХХХ 11.0 сая төгрөг, Сонгинохайрхан дүүргийн ХГБХХХ 4.2 сая төгрөг, Сүхбаатар дүүргийн ХГБХХХ 1.9 сая төгрөг, Чингэлтэй дүүргийн ХГБХХХ 0.3 сая төгрөг/

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 544.8 сая төгрөг болж, өмнөх оноос 65.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбогдсон авлага	38,971.3	48,381.8	9,410.5
Төлбөртэй үйлчилгээний авлага	134,480.8	148,642.3	14,161.5
Татаас санхүүжилтийн авлага	357,939.1	204,907.7	(153,031.4)

**Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Байгууллагаас авах авлага	77,562.1	137,904.2	60,342.1
Хувь хүмүүсээс авах авлага	1,736.0	4,942.5	3,206.4
<b>Дүн</b>	<b>610,689.2</b>	<b>544,778.4</b>	<b>(65,910.8)</b>

*Эх сурвалж: Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Авлагын дансны үлдэгдлийн 8.9 хувийг ажиллагсадтай холбогдсон авлага, 27.3 хувийг төлбөртэй үйлчилгээний авлага, 37.6 хувийг татаас санхүүжилтийн авлага, 25.3 хувийг байгууллагаас авах авлага, 0.9 хувь хүмүүсээс авах авлага эзэлж байна. Авлагын үлдэгдлийн 65.7 хувийг ОУХНЦ-ын 358.1 сая төгрөгийн авлага, 11.5 хувийг ХГБХХЕГ-ын 62.8 сая төгрөгийн авлага тус тус эзэлж байна.

Авлагын дансны үлдэгдэл 65.9 сая төгрөгөөр буурсан нь татаас санхүүжилтийн авлага 153.0 сая төгрөгөөр буурч, байгууллагаас авах авлага 60.3 сая төгрөгөөр өсөж, ОУХНЦ-ын төлбөртэй үйлчилгээний авлага 14.2 сая төгрөгөөр өсөж, ажиллагсадтай холбогдсон авлага 9.4 сая төгрөгөөр өсөж, хувь хүмүүсээс авах авлага 3.2 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

**Аудитын илрүүлэлт:** Харьяа байгууллагуудад авлага данстай холбоотой нийт 217.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- Санхүүгийн тайланд тусгагдсан олон жил болсон нийт 148.2 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй, тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, тайлант онд 2 бэлтгэн нийлүүлэгчид 46.2 сая төгрөг, татвар, нийгмийн даатгалд 4.6 сая төгрөгийг илүү шилжүүлж авлага үүсгэсэн; /ОУХНЦ/
- Жилийн эцсийн санхүүгийн тайланд ажилчидтай холбоотой 9.9 сая төгрөгийн авлага үүсгэсэн; /Орхон аймгийн ХГБХХГ/
- Олон жил болсон 4.5 сая төгрөгийн авлагыг барагдуулах ажил зохин байгуулан ажиллаагүй; /Ховд аймгийн ХГБХХГ/
- Санхүүгийн тайланд 1.3 сая төгрөгийн авлага үүсгэсэн. /Баянзүрх дүүргийн ХГБХХХ/

### 3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 367.0 сая төгрөг болж, өмнөх оноос 291.9 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл*

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	75,074.7	367,023.4	291,948.6
<b>Дүн</b>	<b>75,074.7</b>	<b>367,023.4</b>	<b>291,948.6</b>

*Эх сурвалж: Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 291.9 сая төгрөгөөр буурсан нь ХГБХХЕГ-ын үйл ажиллагаандаа ашиглаж байгаа мэдээллийн технологийн системийн ашиглалтын төлбөрийн 22.4 сая төгрөгийг тайлант онд зардлаар хүлээн зөвшөөрч, шинээр хүүхэд, гэр бүлийн хөгжил оролцоог дэмжих үйл ажиллагааны үйлчилгээний 310.9 сая төгрөг, Сонгинохайрхан дүүргийн ХГБХХХ нь 3.4 сая төгрөгийн дараа онд гарах зардлуудыг бүртгэсэнтэй холбоотой байна.

### 3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 4,879.6 сая төгрөг болж, өмнөх оноос 659.9 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл*

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Түүхий эд материал</b>	<b>123,189.2</b>	<b>126,165.5</b>	<b>2,976.3</b>
Тусгай зориулалттай материал	109,906.2	113,601.4	3,695.2

**Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Эм боох материал	13,282.9	12,564.1	(718.9)
<b>Бэлэн бүтээгдэхүүн</b>	<b>1,121.0</b>	<b>10,046.0</b>	<b>8,925.0</b>
<b>Хангамжийн материал</b>	<b>4,084,537.7</b>	<b>4,729,893.0</b>	<b>645,355.4</b>
Бичиг хэргийн материал	159,639.3	107,991.9	(51,647.4)
Аж ахуйн материал	1,522,914.1	1,991,358.7	468,444.7
Сэлбэг хэрэгсэл	70,531.5	51,639.7	(18,891.8)
Түлш, шатах тослох материал	27,499.3	45,493.3	17,994.0
Барилгын засварын материал	66,902.2	62,914.2	(3,988.0)
Хүнсний материал	303,727.2	300,331.5	(3,395.8)
Бусад хангамжийн материал	1,933,324.0	2,170,163.6	236,839.7
Мал амьтад	10,835.0	13,490.0	2,655.0
<b>Дүн</b>	<b>4,219,682.8</b>	<b>4,879,594.6</b>	<b>659,911.7</b>

*Эх сурвалж: Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материалын үлдэгдлийн 96.9 хувийг хангамжийн материал, 2.6 хувийг түүхий эд материал эзэлж байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 12,167.8 сая төгрөг, хандив тусламжаар 139.9 сая төгрөг, үнэ төлбөргүй шилжүүлж авсан 237.9 сая төгрөг, бусад 15.9 сая төгрөг, нийт 12,561.6 сая төгрөгөөр нэмэгдэж, үйл ажиллагаанд зарцуулсан 11,536.3 сая төгрөг, балансаас баланст шилжүүлсэн 78.7 сая төгрөг, данс хооронд болон акталсан 286.7 сая төгрөг, нийт 11,901.7 сая төгрөгийн бараа материалыг данснаас хасалт хийсэн байна.

Бараа материалын үлдэгдэл нэмэгдэхэд аж ахуйн материал 468.4 сая төгрөгөөр, бусад хангамжийн материал 169.0 сая төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

**Аудитын илрүүлэлт:** ХГБХХЕГ-ын харьяа байгууллагуудад бараа материалын данстай холбоотой нийт 169.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- Бараа материалыг хэрэгцээ шаардлагатай үед нь бодитоор зарлагдаагүй худалдан авсан дүнгээр бөөнд нь зарлагдсан. /Булган аймгийн ХГБХХГ 49.0 сая төгрөг/
- Тооцоо судалгаанд үндэслэхгүйгээр 25.9 сая төгрөгийн бараа материалыг их хэмжээгээр бэлтгэж нөөцөлсөн; /Хан-Уул дүүргийн ХГБХХХ 11.6 сая төгрөг, Сүхбаатар дүүргийн ХГБХХХ 10.8 сая төгрөг Чингэлтэй дүүргийн ХГБХХХ 3.5 сая төгрөг/
- Хөрөнгийн тооллогын комисс нь 13.6 сая төгрөгийн бараа материалын тооллогын бүртгэл хөтлөөгүй, тооцоо бодож баталгаажуулаагүй, 5.7 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлд тооллого хийгээгүй; /Дундговь аймгийн ХГБХХГ 13.6 сая төгрөг, /Сонгинохайрхан дүүргийн ХГБХХХ 5.7 сая төгрөг/
- Тайланд онд худалдан авсан 12.1 сая төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс хэрэглэнд ашиглагдаж байгаа боловч эд хариуцагчид хариуцуулж бүртгэлжүүлээгүй, данснаас хасаж тайлагнасан; /Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байр/

### 3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 84,447.3 сая төгрөг болж, өмнөх оноос 9,871.8 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл*

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>70,774,371.7</b>	<b>79,548,331.3</b>	<b>8,773,959.6</b>
Барилга, байгууламж, орон сууц	55,498,455.3	63,065,998.7	7,567,543.4
Авто-тээврийн хэрэгсэл	1,091,815.2	1,110,673.4	18,858.2
Машин тоног төхөөрөмж (компьютер)	7,181,025.6	9,062,772.6	1,881,747.0
Тавилга, аж ахуйн эд хогшил	2,632,734.6	2,606,084.3	(26,650.2)

**Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Зам, гүүрний байгууламж	5,854.2	4,685.5	(1,168.7)
Бусад үндсэн хөрөнгө	1,851,200.2	1,181,336.7	(669,863.6)
Дуусаагүй барилга, байгууламж	2,410,000.0	2,415,947.9	5,947.9
Номын фонд	103,286.5	100,832.2	(2,454.4)
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>3,801,211.5</b>	<b>4,899,009.8</b>	<b>1,097,798.3</b>
Программ хангамж	28,313.84	482,339.83	454,025.99
Бусад биет бус хөрөнгө	3,772,897.64	4,416,669.92	643,772.29
<b>Дүн</b>	<b>74,575,583.2</b>	<b>84,447,341.0</b>	<b>9,871,757.9</b>

Эх сурвалж: Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн 74.7 хувийг барилга, байгууламж, 1.3 хувийг тээврийн хэрэгсэл, 10.7 хувийг машин тоног төхөөрөмж, 5.8 хувийг биет бус хөрөнгө, 3.1 хувийг тавилга, эд хогшил, 2.9 хувийг дуусаагүй барилга байгууламж, 1.4 хувийг бусад үндсэн хөрөнгө тус тус эзэлж байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 1,217.1 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, хандиваар 1,698.0 сая төгрөг, шилжүүлэн авсан 6,410.5 сая төгрөг, бусад 8,755.4 сая төгрөг, хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоосон 333.5 сая төгрөг, нийт 14,414.6 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдэж, 1,222.4 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 4,227.7 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн, бусад 1,357.9 сая төгрөг, дахин үнэлгээний хорогдол 269.9 сая төгрөг, нийт 7,078.0 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлээс хасалт хийсэн байна.

Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 5,474.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

**Аудитын илрүүлэлт:** Харьяа байгууллагуудад үндсэн хөрөнгийн данстай холбоотой нийт 14,822.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн.Тухайлбал:

- Жилийн эцсийн хөрөнгийн тооллогын комисс нь нийт 10,680.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 397.5 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлд хуульд заасан хугацаанд тооллогыг хийгээгүй, тооцоо бодож баталгаажуулаагүй; /Өнөр бүл хүүхдийн төв/
- Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн ашиглагдаж байгаа нийт 3,616.0 төгрөгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, дансны үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлээгүй; /ОУХНЦ 1,848.4 сая төгрөг, ХГБХХЕГ 1,228.9 сая төгрөг, Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв 210.7 сая төгрөг, Өнөр бүл хүүхдийн төв 141.1 сая төгрөг, Завхан аймгийн ХГБХХГ 99.7 сая төгрөг, Дорнод аймгийн ХГБХХГ 64.8 сая төгрөг, Говьсүмбэр аймгийн ХГБХХГ 13.6 сая төгрөг, Хөвсгөл аймгийн ХГБХХГ 8.6 сая төгрөг/
- Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 56.4 сая төгрөгийн 78.68 м.кв орон сууцны эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг холбогдох байгууллагаар гаргуулан аваагүй, орон сууцыг ашиглуулах эрх бүхий байгууллагын шийдвэргүй, гэрээ байгуулаагүй “Монголын Дауны холбоо” НҮТББ-д үнэ төлбөргүй ашиглуулсан. /ХГБХХЕГ/

### 3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 214.9 сая төгрөг болж, өмнөх оноос 9.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Ажилчидтай холбогдсон өглөг</b>	100,296.9	31,795.0	(68,501.9)
<b>Бараа үйлчилгээний зардлын өглөг</b>	31,700.9	54,271.8	22,571.0
<b>Бусад өглөг</b>	73,076.1	128,913.1	55,837.0
Байгууллагад төлөх өглөг	72,017.3	121,628.8	49,611.5
Хувь хүмүүст төлөх өглөг	1,058.8	7,284.3	6,225.5
<b>Дүн</b>	<b>205,073.8</b>	<b>214,979.9</b>	<b>9,906.1</b>

Эх сурвалж: Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдлийн 14.8 хувийг ажилчидтай холбоотой, 25.2 хувь нь бараа үйлчилгээний зардалтай, 60.0 хувь нь байгууллага, хувь хүмүүстэй холбоотой өглөг тус тус эзэлж байна.

**Аудитын илрүүлэлт:** Харьяа байгууллагуудад өр төлбөрийн данстай холбоотой нийт 8.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- Тайлант онд 8 байгууллагад 4.5 сая төгрөгийн өр төлбөртэй гарсан; /Өнөр бүл хүүхдийн төв/
- Нийслэлийн ХГБХХХ татан буугдаж байгаатай холбоотойгоор Сүхбаатар дүүргийн Татварын хэлтэстэй тооцоо нийлж, санхүүгийн тайланд тусгаагүй ХХОАТ-ын 4.3 сая төгрөгийн олон жил болсон өр төлбөрийг тайлант оны зардлаас төлсөн;

### 3.4.7 Урьдчилж орсон орлого

Нийт урьдчилж орсон орлого дансны үлдэгдэлгүй болж, өмнөх оноос 76.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Урьдчилж орсон орлогын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	-	76,065.1	76,065.1
<b>Дүн</b>	<b>-</b>	<b>76,065.1</b>	<b>76,065.1</b>

Эх сурвалж: Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Олон улсын хүүхдийн найрамдал цогцолбор нь 76.0 сая төгрөгийн урьдчилж орсон орлогыг хүлээн зөвшөөрч тайлагнасан.

### 3.4.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 90,238.7 сая төгрөг болж, өмнөх оноос 10,482.8 сая төгрөгөөр өссөн.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</b>	22,235,381.5	21,530,790.1	(704,591.4)
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	33,896,749.1	46,385,572.1	12,488,823.0
Өмнөх үеийн үр дүн	21,342,644.6	36,005,106.1	14,662,461.5
Тайлант үеийн үр дүн	12,554,104.5	10,380,466.0	(2,173,638.5)
<b>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</b>	23,418,656.1	22,031,330.1	(1,387,325.9)
<b>Дүн</b>	<b>79,755,860.5</b>	<b>90,238,737.4</b>	<b>10,482,876.8</b>

Эх сурвалж: Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо данс өсөхөд 14,662.5 сая төгрөгийн өмнөх үеийн үр дүн голлон нөлөөлсөн.

## 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

ХГБХХЕГ-ын харьяа байгууллагуудын 2025 оны төсвийн төсөлд нийт урсгал үйл ажиллагааны болон хөрөнгийн зарлагыг 107,031.2 сая төгрөгөөр, санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 100,595.9 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 6,435.3 сая төгрөгийг бүрдүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас урсгал үйл ажиллагааны зардлыг 2,231.2 сая төгрөгөөр өсгөж хөрөнгийн санхүүжилтийг 8,836.7 сая төгрөгөөр, үйл ажиллагааны орлогыг 5,221.6 сая төгрөгөөр тус тус өсгөж, 52,406.4 сая төгрөгөөр баталсан байна.

Монгол Улсын 2025 оны төсөвт 1 удаа тодотгол хийж төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр төсвийн урсгал үйл ажиллагааны зардлыг 91,879.4 сая төгрөгөөр, үйл ажиллагааны орлогыг 15,344.8 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2, 42 дугаар зүйлд заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагч ХГБХХЕГ-ын 2025 онд батлагдсан төсвийн хуваарьт 7 удаа төсвийн зохицуулалт хийж урсгал үйл ажиллагааны зардлыг 15,568.4 сая төгрөгөөр бууруулан улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталжээ.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс урсгал үйл ажиллагааны 86,477.6 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 7,028.9 сая төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 81,190.7 сая төгрөгийг зарцуулж, 12,315.8 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны 7,009.9 сая төгрөгийн орлогын төлөвлөгөө батлагдаж, гүйцэтгэлээр 7,071.7 сая төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төлөвлөгөөг 67.7 сая төгрөгөөр давуулан биелүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 81,190.7 сая төгрөг буюу 86.8 хувьтай байна. Энэ нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 5,424.2 сая төгрөг, хамгаалах нөхөн сэргээх 3,139.8 сая төгрөгөөр, урьдчилан сэргийлэх арга хэмжээг 714.6 сая төгрөгөөр, хүүхэд харах үйлчилгээг 939.5 сая төгрөгөөр, нөхцөл байдлын үнэлгээ хийх зардал 661.0 сая төгрөгөөр, хөгжил оролцоо арга хэмжээг 591.1 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

					<i>/мянган төгрөг/</i>
Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувь/
	<b>Нийт зардлын дүн</b>	<b>93,506,521.4</b>	<b>81,190,749.5</b>	<b>12,315,771.8</b>	<b>86.8</b>
<b>72207</b>	<b>Хүүхдийн хөгжил хамгаалал</b>	<b>93,506,521.4</b>	<b>81,190,749.5</b>	<b>12,315,771.8</b>	<b>86.8</b>
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	66,485,325.3	61,061,109.1	5,424,216.2	91.8
80102	Туслах үйл ажиллагаа	878,585.4	803,120.6	75,464.8	91.4
80231	Хүүхэд харах үйлчилгээ	3,626,321.6	2,686,811.4	939,510.2	74.1
80236	Нөхцөл байдлын үнэлгээ хийх зардал	1,417,737.4	756,735.3	661,002.1	53.4
80237	Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ	9,244,040.3	6,104,252.1	3,139,788.2	66.0
80238	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	4,864,456.0	4,149,887.5	714,568.5	85.3
80240	Хөгжил оролцоо	4,839,964.9	4,248,862.6	591,102.3	87.8
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	1,650,090.5	1,043,175.7	606,914.8	63.2
82103	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	500,000.0	336,795.3	163,204.7	67.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайланд онд нэмэлт санхүүжилтийн дансанд Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 342.1 сая төгрөг, ЗГНХ, ЗДНХерөнгө, түүнтэй адилтгах

ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 3,969.4 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 7,264.5 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,014.1 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ. Үүнээс татаас санхүүжилтийн авлагаар 378,0 сая төгрөгийг бүртгэж, Сангийн яамны төрийн сантай тооцоо нийлж актаар баталгаажуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

ХГБХХЕГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/211 дүгээр тушаалаар нийт 1,438.0 сая төгрөгийн зарцуулахаар баталж, 4 худалдан авалтыг "Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем"-ээр зохион байгуулжээ. Үүнд:

- Хүүхэд, гэр бүлийн хөгжил оролцоог дэмжих үйл ажиллагааны ажлын хүрээнд 938.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй худалдан авалтыг нэг үүсвэрээс худалдан авах ажиллагааны аргыг хэрэглэн "Аргун студио" ХХК-тай "Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын үйл ажиллагааг цахим технологийн тусламжтай иргэн бүрд хүртээмжтэй хүргэх" ажил гүйцэтгэх гэрээг 535.3 сая төгрөгөөр байгуулж, 997,000 ширхэг гар утсанд татан суулгах QR бүхий, зурагтай наадаг стикерийн зардалд 224.3 сая төгрөг, "Гэр бүлийн виртуал зөвлөх" үйлчилгээг 3 жилийн хугацаатай ашиглах зардалд 310.9 сая төгрөгийг зарцуулсан;
- "Сургалт, хөгжүүлэлтийн нэгдсэн тогтолцооны дашбоард бэлтгүүлэх" 250.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй худалдан авалтыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулж хамгийн бага үнийн санал ирүүлсэн "Бид солишин" ХХК-тай гэрээ байгуулж, гүйцэтгэлээр нийт 215.0 сая төгрөгийг олгосон;
- "Хүүхэд, гэр бүлийн мэдээллийн сан үйлчилгээ" 130.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй үйлчилгээний худалдан авалтыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулж, шалгарсан Орон нутгийн хөгжлийн бодлого судлалын төв нийтэд үйлчилдэг төрийн бус байгууллагатай гэрээ байгуулж, гүйцэтгэлээр нийт 107.5 сая төгрөгийг олгосон;
- Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн индекс 120.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй худалдан авалтыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулж, шалгарсан "Эйблсофт" ХХК-тай гэрээ байгуулж, гүйцэтгэлээр нийт 112.4 сая төгрөгийг олгосон;

**Аудитын илрүүлэлт:** ХГБХХЕГ-ын харьяа байгууллагуудад худалдан авах ажиллагаатай холбоотой нийт 1,808.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаараас давсан /20.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий/ 1,143.2 сая төгрөгийн бараа материалын худалдан авалтыг 17 аж ахуйн нэгжээс шууд худалдан авалт хийсэн. /ОУХНЦ/
- Нэг төрлийн ижил бараа ажил үйлчилгээний төсөвт өртгийг хуваан нийт 244.1 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн. /ХГБХХЕГ нь 149.2 сая төгрөг, Төв аймгийн ХГБХХГ 54.6 сая төгрөг, Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байр 40.3 сая төгрөг/
- Зорилтод бүлгийн хүүхдүүдийг "Зуслан хөтөлбөр"-т хамруулах арга хэмжээг зохион байгуулахдаа сонгон шалгаруулалт явуулалгүйгээр нэг аж ахуй нэгжтэй шууд гэрээ байгуулж 76.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон. /Чингэлтэй дүүргийн ХГБХХХ/
- Нээлттэй тендер шалгаруулалтаар шалгарсан 5 аж ахуйн нэгжээс гэрээний үнийн дүнгийн 20.0 хувиас илүү үнийн дүнтэй худалдан авалт хийж 107.0 сая төгрөгийг илүү зарцуулсан. /ОУХНЦ/

- Төсвийн хөрөнгөөр 237.0 сая төгрөгийн бараа худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан аваагүй; /Чингэлтэй дүүргийн ХГБХХХ 118.2 сая төгрөг, Сүхбаатар дүүргийн ХГБХХХ 113.1 сая төгрөг, Булган аймгийн ХГБХХГ 5.7 сая төгрөг/

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 6 төрлийн судалгаа авч үр дүнг тайланд тусгалаа. Үүнд:

- 2025 онд 1,112 албан хаагч ажиллаж байсан бөгөөд 9.1 хувь буюу 101 гүйцэтгэх албан тушаалтныг бууруулж, 1,011 орон тоотой ажиллахаар батлагдсан. ГБХНХС-ын 2025 оны 09 дүгээр сарын 03-ний өдрийн А/164 дугаар тогтоолоор Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын төв, орон нутгийн байгууллагын орон тооны хязгаарыг сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны 833 орон тоог нэмж 1,844 байхаар баталсан боловч 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгаснаар 1,172 орон тоотой ажилласан байна.
- ХГБХХЕГ-ын харьяа байгууллагын тайлант онд унаа, хоолны хөнгөлөлтийн зардалд 7,174.4 сая төгрөг төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 6,668.7 сая төгрөгийг зарцуулж, гүйцэтгэл 92.5 хувь байна. Нийслэл, дүүргийн хэлтсийн ажилчдын хоол унааны зардал дунджаар 35.0 мянган төгрөг, нийгмийн ажилтны хоол унааны зардал 25.0 мянган төгрөг, харьяа байгууллагын албан хаагчдын хоол унааны зардал дунджаар 22.5 мянган төгрөг байна. Орон нутгийн албан хаагчдын хоол унааны зардал 3 аймаг 20.0 мянган төгрөг, 16 аймаг 15.0 мянган төгрөг, 1 аймаг 12.0 мянган төгрөг, аймаг 8.0 мянган төгрөгөөр тогтоосон нь харилцан адилгүй байна.
- Гадаад томилолт, арга хэмжээний талаар: Гадаад арга хэмжээний болон томилолтын зардал батлагдаагүй байна. Гэвч тайлант онд дотоод албан томилолтын зардлаас 16.5 сая төгрөг, сургалт, дадлага, бэлтгэлийн зардлаас 7.9 сая төгрөг, мэргэжлийн үйлчилгээний зардлаас 11.5 сая төгрөг, нийт 35.9 сая төгрөгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр гадаад албан томилолтын зардалд зарцуулжээ.
- Тайлант хугацаанд хичээл, үйлдвэрлэлийн зардалд 2,916.7 сая төгрөгийг төсөвлөж, гүйцэтгэлээр 2,346.5 сая төгрөгийг зарцуулсан. Нийгмийн ажилтны сургалт, хүүхдийн чуулган, хамтарсан багийн зөвлөгөөн, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль сурталчлах, Гэр бүлийн боловсрол олгох арга зүйг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, "Сургагч багш" бэлтгэх, чадавхжуулах сургалт зэрэг сургалтуудыг зохион байгуулсан байна.
- Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын хэрэгжүүлж буй ажил, мэдээ, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэхээр мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэдэд хүргэх ажлын хүрээнд 29 хуулийн этгээдтэй 168.8 сая төгрөгийн гэрээ байгуулж, гүйцэтгэлээр 154.6 сая төгрөгийг санхүүжүүлж үлдэгдэл 14.2 сая төгрөгийн өглөг үүсгэсэн байна.
- ХГБХХЕГ-ын харьяа байгууллагаас төрд учирсан хохирлыг төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал байхгүй болно.
- ХГБХХЕГ нь салбарын нийт албан хаагчдыг сургалтад хамруулахад зарцуулдаг зардлыг багасгах зорилгоор төсвийн хөрөнгөөр “Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын салбарын албан хаагчид, оролцогчдыг чадавхжуулах” сургалтын нэгдсэн платформыг 215.0 сая төгрөгөөр, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын анхдагч өгөгдөлд суурилсан “Үр дүнгийн цахим самбар” статистик мэдээллийн дашбоардыг 219.9 сая төгрөгөөр тус тус хийлгэсэн байна. Уг систем нь хүүхэд, гэр бүлийн хөгжлийн индексийг тооцох аргачлалыг боловсруулж, 9 дүүрэг, 21 аймгийн бүх сумдын “Амьдрах, хөгжих эрх”-тэй уялдуулан 5 хүртэлх насны болон нярайн эндэгдэл, хоол тэжээлийн дутал, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, вакцинжуулалт, эрт хөгжлийн индекс, боловсролын хамран сургалт зэрэг үзүүлэлтүүдийг тусгасан хүүхэд эрүүл өсөж, сурч хөгжих эрхээ бодитой эдэлж байгаа эсэхийг тоон хэлбэрээр илэрхийлдэг юм.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу ХГБХХЕГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн ХГБХХЕГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой төсвийн зарцуулалт, зардлын эдийн засгийн ангилал, авлага, дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын аудитор Д.Номингуа гүйцэтгэж, үе шатны хяналтыг ахлах аудитор Б.Ариунжаргал, аудитын менежер А.Цогбаяр, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

ХГБХХЕГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01/191 дугаар албан бичгээр 2026 оны 03 дугаар сарын 05-ний өдөр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан, суурь үзүүлэлтээр нийт зардлаас 1.0 хувиар тогтоон сонгосон суурь үзүүлэлтээс тооцож, төлөвлөлтийн материаллаг байдлыг 747.7 сая төгрөгөөр тогтоож баримтжууллаа.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан төсвийн төслийн саналаар хүргүүлсэн зарим зардлыг татаж баталсан, аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудиттай холбоотой нийт 20,093.9 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 1.3 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 13,139.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах 15 албан шаардлагыг хүргүүлж, 1 албан хаагчид 343.8 сая төгрөгийн 1 хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж, 6,609.4 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 33 зөвлөмж өгсөн байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 17 байгууллагад шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулаагүй, хугацаа хоцруулсан зэрэг нийт 18,550.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн, үүнээс 7 байгууллага нь зөрчлийг давтан гаргасан нь Дотоод аудит, мониторингийн газраас хуулийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:", 6.4.3-т "тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.1-д "Төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх;", 15 дугаар зүйлийн 15.4-д "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:", 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;" гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна. .

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулаагүй, хугацаа хоцруулсан, зөрчлийг давтан гаргасан, дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй зэрэг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

*Илрүүлэлт:* ХГБХХЕГ нь 36 харьяа байгууллагаас 15 байгууллагад /Хүүхдийн ордон, Хөгжлийн төв, ОУХНЦ, Өнөр бүл төв зэрэг/ ашиглаж байгаа хэрэглэгдэхүүнийг шинэчлэх, хүртээмжийг нэмэгдүүлэхэд нийт 238.4 сая төгрөгийг зарцуулж, үлдсэн 21 байгууллагыг хамруулаагүй нь хүүхэд хөгжих эрх тэгш байдлыг хангахгүй нөхцөл байдал үүсгэсэн байна.

Энэ нь Хүүхдийн эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй байх;", 4.1.2-д "төр, иргэн, хуулийн этгээд үйл ажиллагаа явуулахдаа хүүхдийн язгуур эрхийг эн тэргүүнд хангахыг эрхэмлэж, хүүхэд эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг тэгш хангах;", 4.1.7-д "хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ нь хүүхдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн байх;", 4.1.8-д "хүүхдийн эрхийг хангахад оролцогч талуудын үйл ажиллагаанд хуульд заасан төрийн болон албаны нууц, хүний эмзэг мэдээлэлд хамаарахаас бусад мэдээлэл ил тод, нээлттэй байх." заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагуудад үзүүлж байгаа хөрөнгө, санхүүгийн дэмжлэгийг харьяа байгууллагуудад тэгш хүртээж байх арга хэмжээ авч ажиллах.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

ХГБХХЕГ-ын 2025 оны III улирлын санхүүгийн тайланд завсрын аудит хийж илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл хөтөлж, шалгагдагч байгууллагад танилцуулсан. Завсрын аудитаар ХГБХХЕГ, Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ түр хамгаалах байр, хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв, ОУХНЦ-т нийт 4,259.8 сая төгрөгийн

алдаа, зөрчил илрүүлж, 2,254.1 сая төгрөгийн 6 алдааг залруулах, 2,005.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах талаар 21 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг жилийн эцсийн байдлаар нэгтгэн дүгнэж, хэрэгжилтийг үнэлэхэд дараах байдалтай байна. Тухайлбал:

- Нэмэлт санхүүжилтийн дансаар НҮБ-ын хүүхдийг ивээх сангаас санхүүжүүлсэн "Хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн систем PRIMERO-г нэвтрүүлэх" үйл ажиллагаанд зориулан олгосон санхүүжилтээс 4.3 сая төгрөгийг ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүйн улмаас санхүүжилтийг буцаан татуулсан, жилийн эцсийн аудитаар хэрэгжилтийг үнэлэхэд гүйцэтгэгч компани дутуу хэрэгжүүлсэн ажлыг дуусгаж санхүүжилтээ авсан. /ХГБХХЕГ/
- Шалгагдагч байгууллагад 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр 26 нэр төрлийн нийт 54.6 сая төгрөгийн шинээр орлого авсан хөрөнгөд хяналтын, түүвэрчилсэн тооллого хийж гүйцэтгэхэд эд хариуцагч бүрээр хөрөнгийн карт хөтлөөгүй, хөрөнгө тус бүрийг кодолж бүртгээгүй./Өнөр бүл хүүхдийн төв/
- Үндсэн хөрөнгийн шинж чанартай 4.9 сая төгрөгийн үнэ бүхий 2 төрлийн сүлжээний свич төхөөрөмжийг бараа материалын дансанд бүртгэснийг залруулж, үндсэн хөрөнгөд бүртгэсэн. /ХГБХХЕГ/
- ХГБХХЕГ-ын эзэмшил дэх 2 газрыг байгууллагын хөрөнгөд бүртгээгүй зөрчлийг арилгаж хөрөнгөд бүртгэн, тайлагнасан.
- Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй "Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвийн дуудлагын программ, веб программ"-д 9.0 сая төгрөгөөр засвар үйлчилгээ, хөгжүүлэлт хийлгэж, программыг капиталжуулалгүйгээр шууд зардалд бүртгэсэн байна. /Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв/
- Мөнгөн гүйлгээний журналд 11.7 сая төгрөгийн ажил гүйлгээг шууд зардлаар бүртгэсэн. /Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв/
- Харуул хамгаалалтын зардлыг 3 дугаар улирлын байдлаар 39.9 сая төгрөгөөр батлагдсан төсвөөс илүү зарцуулсан байна. /Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байр/

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар харьяа байгууллагуудад 99.8 сая төгрөгийн 30 төлбөрийн акт тогтоосныг 88.6 сая төгрөгийг барагдуулж, 19,121.2 сая төгрөгийн 66 албан шаардлага хүргүүлснээс 19,063.1 сая төгрөгийн 64 албан шаардлагыг бүрэн биелүүлж, 1,663.2 сая төгрөгийн 91 зөвлөмж өгснөөс бүрэн хэрэгжүүлж, 162.4 сая төгрөгийн 1 хариуцлага тооцуулах албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж аудитын шийдвэрийн хэрэгжилт 82.8 хувьтай байна.

Хүснэгт-13 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	30	99,826.70	29	88,614.30	88.8
Албан шаардлага	66	19,121,223.62	64	19,063,073.62	99.7
Зөвлөмж	91	1,663,157.50	91	1,663,157.50	100.0
Хариуцлага тооцуулах	1	162,450.00	1	162,450.00	100.0
<b>Дүн</b>	<b>188</b>	<b>6,786,313.10</b>	<b>106</b>	<b>5,618,786.60</b>	<b>82.8</b>

Өмнөх оны аудитаар өгсөн аудитын шийдвэрээс дараах зөрчлийг бүрэн хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал:

- ХГБХХЕГ нь өмнөх оны аудитаар өгөгдсөн нэр бүхий 15 ажилтанд нийт 11.2 сая төгрөгийн цалинг илүү тооцож олгосон төлбөрийн актыг төлж барагдуулаагүй.
- “Хурдан морь уралдаанч хүүхдийн бүртгэлийн систем хөгжүүлэх” ажлыг 19.2 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр “Эйблсофт” ХХК-тай, мөн “Хүүхдийн эрхийн хууль зүйн

хорооноос үйлчилгээ авч буй хүүхдүүдийн бүртгэлийн систем хөгжүүлэх ажлын даалгавар боловсруулах, зөвлөх үйлчилгээ авах” ажлыг 19.4 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр “Дийг Ай Ти” ХХК-тай тус тус гэрээ байгуулсан боловч систем хөгжүүлэгчийг сонгон шалгаруулаагүйгээс ажлын даалгаварт заасан систем хөгжүүлэх, нэвтрүүлэх явцад хяналт тавих, хөгжүүлэгчээс гүйцэтгэлийг хүлээн авах, захиалагчдад хүлээлгэн өгөх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэлгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон.

- "Гэртээ эрт харья" аяныг зохион байгуулахаар Нийслэлийн мэдээллийн төвтэй 19.5 сая төгрөгийн гэрээ байгуулан урьдчилгаа санхүүжилт 13.6 сая төгрөгийг олгосон боловч гэрээний хугацаа дууссан, хэрэгжилтийг бүрэн хангуулаагүй.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар дараах горим сорилыг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т төсвийн шууд захирагч нь зөвхөн өөрийн урсгал зардалд төсвийн зохицуулалт хийхээр заасан боловч харьяа шууд захирагчийн урсгал зардлыг санхүүжүүлсэн, зардлын эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийж, тайлагнасан эсэхэд;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг шалгах;
- Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод газрын үйл ажиллагаа, шийдвэрийн хэрэгжилт;

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

ХГБХХЕГ-н төсвийн төвлөрүүлэн захирагч болон харьяа байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 12,837.2 сая төгрөгийн 67 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 19,514.7 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрч, 35.9 сая төгрөгийн зөрчилд 21 төлбөрийн акт тогтоож, 16,861.7 сая төгрөгийн зөрчилд 53 албан шаардлага, 24.0 сая төгрөгийн зөрчилд 2 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 2 албан шаардлага хүргүүлж, 2,593.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 64 зөвлөмжийг өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 19,514.7 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 18,767.0 сая төгрөгөөр их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### 5.1 Хүүхэд гэр бүл хөгжил, хамгааллын ерөнхий газрын харьяа байгууллагууд:

ХГБХХЕГ-ын харьяа байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 36 төсвийн захирагч нарын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 31 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллагын санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 22 байгууллагад “Өөрчлөлтгүй”, 9 байгууллагад (ХГБХХЕГ, Өнөр бүл хүүхдийн төв, ОУХНЦ, Дундговь аймгийн ХГБХХГ, Ховд аймгийн ХГБХХГ, Нийслэлийн ХГБХХГ, Чингэлтэй дүүргийн ХГБХХ, Сүхбаатар аймгийн ХГБХХХ, Хан-Уул дүүргийн ХГБХХХ) “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

ХГБХХЕГ-н харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 12,257.1 сая төгрөгийн 65 алдаа илэрснээс 12,257.1 сая төгрөгийн 65 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 19,074.6 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 35.9 сая төгрөгийн зөрчилд 21 төлбөрийн акт тогтоон, 16,426.8 сая төгрөгийн зөрчилд 51 албан шаардлага, 24.0 сая төгрөгийн зөрчилд 2 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 2 албан шаардлага хүргүүлж, 2,587.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах 63 зөвлөмжийг өгсөн.

### 5.2.Төсвийн төвлөрүүлэн захирагч:

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 1,020.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 580.1 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 434.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 албан шаардлагыг хүргүүлж, 5.2 сая төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

#### 5.2.1. Албан шаардлага

5.2.1.1. Тайлант онд нээлттэй тендер шалгаруулалтын аргыг ашиглан нийт 434.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төрлийн худалдан авах ажиллагааны тендерийн шалгаруулалтын баримт бичигт гүйцэтгэлийн баталгааны талаар тусгаагүй, баталгааг гаргуулаагүй, санхүүжилтийг бүрэн олгосон. Үүнд:

- Сургалтын нэгдсэн платформ боловсруулах 215.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил;
- Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн индекс боловсруулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө 107.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил;

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- Хүүхэд, гэр бүлийн мэдээллийн сан боловсруулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх 112.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"; 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;"; 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;"; Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана.", 42.2-т "Захиалагч гүйцэтгэлийн баталгааны дүнг тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувиар тогтоож тендер шалгаруулалтын баримт бичигт тусгана." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлээгүй, гүйцэтгэлийн баталгааг тендерийн баримт бичигт тусгаагүй, баталгаа гаргуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.2.1.2. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 36 байгууллагын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 31,331.8 сая төгрөгийн 202 алдаа, зөрчил илэрснээс 12,257.1 сая төгрөгийн алдааг залруулга хийлгэж, санхүүгийн тайлагналтай холбоотой 19,074.6 сая төгрөгийн 137 зөрчил илэрсэн нь төсвийн төвлөрүүлэн захирагчаас санхүү, нягтлан бодох бүртгэлд тавих дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-т "хариуцлагатай байх", 6.6.1-д "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх;"; 15.4-д "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ."; 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;"; 16 дугаар зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй, зөрчлийг таслан зогсоож, алдаа зөрчлийг 20-оос доошгүй хувиар бууруулах арга хэмжээг авч ажиллах албан шаардлагыг хүргүүлэв.

## 5.2.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Бараа материалтай холбоотой асуудал:

Илрүүлэлт 1. НҮБ-ын Хүүхдийн сангаас кейс менежментийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор харьяа 2 байгууллагад хуваарилсан 5.2 сая төгрөгийн 4 ширхэг таблетыг үндсэн хөрөнгөд бүртгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-д "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ:; 41.2.1.хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үнэ төлбөргүй үндсэн хөрөнгийг хүлээлцэхэд акт үйлдэж, үндсэн хөрөнгийг бүртгэлд бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн  
нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар ТТЗ	2	580,096.2	-	-	2	580,096.2	2	580,096.2	-	-
Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар ТШЗ	6	552,121.4	-	-	6	552,121.4	6	552,121.4	-	-
Өнөр бүл хүүхдийн төв	2	101,146.6	-	-	2	101,146.6	2	101,146.6	-	-
Олон улсын хүүхдийн найрамдал цогцолбор	3	328,209.7	2	318,529.7	1	9,680.0	3	328,209.7	-	-
Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв	3	1,161,217.1	1	1,154,220.3	2	6,996.8	3	1,161,217.1	-	-
Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байр	4	1,154,079.2	-	-	4	1,154,079.2	4	1,154,079.2	-	-
Говь-Алтай аймгийн ХГБХХГ	1	331,252.6	-	-	1	331,252.6	1	331,252.6	-	-
Говьсүмбэр аймгийн ХГБХХГ	1	10,303.5	-	-	1	10,303.5	1	10,303.5	-	-
Дорноговь аймгийн ХГБХХГ	1	54,707.4	-	-	1	54,707.4	1	54,707.4	-	-
Дундговь аймгийн ХГБХХГ	1	862.0	-	-	1	862.0	1	862.0	-	-
Завхан аймгийн ХГБХХГ	2	83,012.4	-	-	2	83,012.4	2	83,012.4	-	-
Сэлэнгэ аймгийн ХГБХХГ	3	20,869.1	1	2,978.0	2	17,891.1	3	20,869.1	-	-
Төв аймгийн ХГБХХГ	5	116,216.1	2	45,716.5	3	70,499.6	5	116,216.1	-	-
Ховд аймгийн ХГБХХГ	6	154,238.9	-	-	6	154,238.9	6	154,238.9	-	-
Өвөрхангай аймгийн ХГБХХГ	2	1,588.5	1	300.0	1	1,288.5	2	1,588.5	-	-
Налайх дүүргийн ХГБХХХ	1	9,802.8	-	-	1	9,802.8	1	9,802.8	-	-
Сонгинохайрхан дүүргийн ХГБХХХ	4	202,410.5	2	5,171.0	2	197,239.5	4	202,410.5	-	-
Чингэлтэй дүүргийн ХГБХХХ	1	4,664.7	-	-	1	4,664.7	1	4,664.7	-	-
Сүхбаатар дүүргийн ХГБХХХ	2	103,398.1	-	-	2	103,398.1	2	103,398.1	-	-
Хан-Уул дүүргийн ХГБХХХ	2	2,987,567.5	1	2,973,660.0	1	13,907.5	2	2,987,567.5	-	-
Баянгол дүүргийн ХГБХХХ	6	205,296.4	2	33,173.6	4	172,122.8	6	205,296.4	-	-
Баянзүрх дүүргийн ХГБХХХ	5	4,406,938.7	1	3,670,407.3	4	736,531.4	5	4,406,938.7	-	-
Багануур дүүргийн ХГБХХХ	1	141,724.8	1	141,724.8	-	-	1	141,724.8	-	-
Багахангай дүүргийн ХГБХХХ	3	125,509.2	-	-	3	125,509.2	3	125,509.2	-	-
<b>Дүн</b>	<b>67</b>	<b>12,837,233.4</b>	<b>14</b>	<b>8,345,881.2</b>	<b>53</b>	<b>4,491,352.2</b>	<b>67</b>	<b>12,837,233.4</b>	<b>-</b>	<b>-</b>

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар ТТЗ	3	440,106.2	-	-	2	434,878.5	1	5,227.7	-	-
Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар ТШЗ	12	2,453,070.8	1	4,804.4	10	2,421,605.5	1	26,660.9	-	-
Өнөр бүл хүүхдийн төв	6	11,430,396.8	1	325.0	3	11,289,006.2	2	141,065.6	-	-
Олон улсын хүүхдийн найрамдал цогцолбор	7	2,188,889.5	-	-	6	2,187,138.5	1	1,751.0	-	-
Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв	6	250,319.2	1	1,810.8	3	36,170.1	2	212,338.4	-	-
Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байр	5	139,534.4	-	-	4	127,406.4	1	12,128.0	-	-
Архангай аймгийн ХГБХХГ	3	3,527.6	1	863.6	2	2,664.0	-	-	-	-
Баянхонгор аймгийн ХГБХХГ	1	-	-	-	1	-	-	-	-	-
Булган аймгийн ХГБХХГ	2	51,559.8	-	-	-	-	2	51,559.8	-	-
Говь-Алтай аймгийн ХГБХХГ	3	537.4	1	537.4	-	-	2	-	-	-
Говьсүмбэр аймгийн ХГБХХГ	1	13,648.7	-	-	-	-	1	13,648.7	-	-
Дархан-Уул аймгийн ХГБХХГ	2	4,355.7	1	133.0	-	-	1	4,222.7	-	-
Дорнод аймгийн ХГБХХГ	4	112,457.5	-	-	1	23,648.0	1	64,809.5	2	24,000.0
Дундговь аймгийн	4	45,942.2	-	-	3	45,942.2	1	-	-	-
Завхан аймгийн ХГБХХГ	3	126,998.7	1	5,310.6	1	21,960.5	1	99,727.6	-	-
Сүхбаатар аймгийн ХГБХХГ	3	-	-	-	-	-	3	-	-	-
Орхон аймгийн ХГБХХГ	3	11,734.1	2	1,770.0	-	-	1	9,964.1	-	-
Сэлэнгэ аймгийн ХГБХХГ	3	10,842.8	1	323.9	2	10,518.9	-	-	-	-
Төв аймгийн ХГБХХГ	6	6,784.6	5	6,784.6	-	-	1	-	-	-
Ховд аймгийн ХГБХХГ	8	134,562.4	1	3,073.5	-	-	7	131,488.9	-	-
Хөвсгөл аймгийн ХГБХХГ	4	22,407.4	-	-	1	5,766.9	3	16,640.5	-	-
Нийслэлийн ХГБХХГ	5	1,227,902.8	-	-	-	-	5	1,227,902.8	-	-
Налайх дүүргийн ХГБХХХ	2	16,473.2	-	-	-	-	2	16,473.2	-	-
Сонгинохайрхан дүүргийн ХГБХХХ	4	17,727.1	1	1,072.9	1	5,764.3	2	10,889.9	-	-
Чингэлтэй дүүргийн ХГБХХХ	8	310,827.2	-	-	3	150,878.6	5	159,948.6	-	-
Сүхбаатар дүүргийн ХГБХХХ	8	281,592.0	-	-	4	36,343.4	4	245,248.6	-	-
Хан-Уул дүүргийн ХГБХХХ	12	148,579.3	3	7,766.8	3	31,560.0	6	109,252.5	-	-

**Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Баянгол дүүргийн ХГБХХХ	5	22,381.9	-	-	-	-	5	22,381.9	-	-
Баянзүрх дүүргийн ХГБХХХ	3	22,340.9	-	-	2	21,045.1	1	1,295.8	-	-
Багануур дүүргийн ХГБХХХ	2	8,815.7	1	1,365.0	-	-	1	7,450.7	-	-
Багахангай дүүргийн ХГБХХХ	2	10,440.0	-	-	1	9,440.0	1	1,000.0	-	-
<b>Дүн</b>	<b>140</b>	<b>19,514,755.9</b>	<b>21</b>	<b>35,941.5</b>	<b>53</b>	<b>16,861,737.1</b>	<b>64</b>	<b>2,593,077.4</b>	<b>2</b>	<b>24,000.0</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>										
Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар ТШЗ	1	10,667,165.7	-	-	1	10,667,165.7	-	-	-	-
Өнөр бүл хүүхдийн төв	1	-	-	-	-	-	1	-	-	-
Олон улсын хүүхдийн найрамдал цогцолбор	1	343,776.1	-	-	-	-	-	-	1	343,776.1
Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв	1	261,123.9	-	-	-	-	1	261,123.9	-	-
Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байр	1	399,180.1	-	-	-	-	1	399,180.1	-	-
Дархан-Уул аймгийн ХГБХХГ	1	644,992.4	-	-	1	644,992.4	-	-	-	-
Дорнод аймгийн ХГБХХГ	1	258,421.7	-	-	1	258,421.7	-	-	-	-
Дундговь аймгийн ХГБХХГ	1	84,907.2	-	-	-	-	1	84,907.2	-	-
Өмнөговь аймгийн ХГБХХГ	1	338,925.4	-	-	-	-	1	338,925.4	-	-
Увс аймгийн ХГБХХГ	1	3,714,760.2	-	-	-	-	1	3,714,760.2	-	-
Нийслэлийн ХГБХХГ	1	371,576.2	-	-	-	-	1	371,576.2	-	-
Налайх дүүргийн ХГБХХХ	1	57,424.2	-	-	-	-	1	57,424.2	-	-
Чингэлтэй дүүргийн ХГБХХХ	1	-	-	-	1	-	-	-	-	-
Сүхбаатар дүүргийн ХГБХХХ	1	-	-	-	1	-	-	-	-	-
Баянзүрх дүүргийн ХГБХХХ	1	1,342,388.5	-	-	-	-	1	1,342,388.5	-	-
Багануур дүүргийн ХГБХХХ	1	-	-	-	-	-	1	-	-	-
Багахангай дүүргийн ХГБХХХ	1	66,134.1	-	-	1	66,134.1	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>17</b>	<b>18,550,775.7</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>6</b>	<b>11,636,713.9</b>	<b>10</b>	<b>6,570,285.7</b>	<b>1</b>	<b>343,776.1</b>

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<i>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</i>										
Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар ТТЗ	2	-	-	-	1	-	1	-	-	-
Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар ТШЗ	9	74,834.4	-	-	3	69,362.4	6	5,472.0	-	-
Өнөр бүл хүүхдийн төв	1	-	-	-	-	-	1	-	-	-
Олон улсын хүүхдийн найрамдал цогцолбор	1	1,143,248.7	-	-	1	1,143,248.7	-	-	-	-
Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв	1	22,500.0	-	-	-	-	1	22,500.0	-	-
Булган аймгийн ХГБХХГ	2	6,760.0	1.0	1,000.0	-	-	1	5,760.0	-	-
Дорнод аймгийн ХГБХХГ	1	-	-	-	-	-	1	-	-	-
Дундговь аймгийн ХГБХХГ	1	290.0	1.0	290.0	-	-	-	-	-	-
Төв аймгийн ХГБХХГ	1	54,626.0	-	-	1	54,626.0	-	-	-	-
Ховд аймгийн ХГБХХГ	1	5,356.5	-	-	-	-	1	5,356.5	-	-
Хэнтий аймгийн ХГБХХГ	1	4,220.5	-	-	1	4,220.5	-	-	-	-
Нийслэлийн ХГБХХГ	2	-	-	-	-	-	2	-	-	-
Налайх дүүргийн ХГБХХХ	1	-	-	-	-	-	1	-	-	-
Сонгинохайрхан дүүргийн ХГБХХХ	1	-	-	-	-	-	1	-	-	-
Чингэлтэй дүүргийн ХГБХХХ	2	118,233.2	-	-	1	118,233.2	1	-	-	-
Сүхбаатар дүүргийн ХГБХХХ	2	113,054.0	-	-	1	113,054.0	1	-	-	-
Хан-Уул дүүргийн ХГБХХХ	1	-	-	-	-	-	1	-	-	-
Баянгол дүүргийн ХГБХХХ	1	-	-	-	-	-	1	-	-	-
Баянзүрх дүүргийн ХГБХХХ	1	-	-	-	-	-	1	-	-	-
Багануур дүүргийн ХГБХХХ	1	-	-	-	-	-	1	-	-	-
Багахангай дүүргийн ХГБХХХ	1	-	-	-	-	-	1	-	-	-
<b>Дүн</b>	<b>34</b>	<b>1,543,123.3</b>	<b>2</b>	<b>1,290.0</b>	<b>9</b>	<b>1,502,744.8</b>	<b>23</b>	<b>39,088.5</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Нийт дүн</b>	<b>51</b>	<b>20,093,899.0</b>	<b>2</b>	<b>1,290.0</b>	<b>15</b>	<b>13,139,458.7</b>	<b>33</b>	<b>6,609,374.2</b>	<b>1</b>	<b>343,776.1</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1117/A0171254

Улаанбаатар хот

САГ-2026/16/НА-СТА-ТТЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд нээлттэй тендер шалгаруулалтын аргыг ашиглан нийт 434,878,529.00 /дөрвөн зуун гучин дөрвөн сая найман зуун далан найман мянга таван зуун хорин есөн/ төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төрлийн худалдан авах ажиллагааны тендерийн шалгаруулалтын баримт бичигт гүйцэтгэлийн баталгааг тусгаагүйгээс баталгаа гаргуулж аваагүй, санхүүжилтийг бүрэн олгосон байна. Үүнд:

1. Сургалтын нэгдсэн платформ боловсруулах 215,000,000.00 /хоёр зуун арван таван сая/ төгрөгийн төсөвт өртөгтэй ажил;
2. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн индекс боловсруулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө 107,470,000.00 /нэг зуун долоон сая дөрвөн зуун далан мянган/ төгрөгийн төсөвт өртөгтэй ажил;
3. Хүүхэд, гэр бүлийн мэдээллийн сан боловсруулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх 112,408,529.00 /нэг зуун арван хоёр сая дөрвөн зуун найман мянга таван зуун хорин есөн/ төгрөгийн төсөвт өртөгтэй ажил.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"; 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"; 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"; Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана.", 42.2-т "Захиалагч гүйцэтгэлийн баталгааны дүнг тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувиар тогтоож тендер шалгаруулалтын баримт бичигт тусгана." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн баталгааг гаргуулж авдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх,
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Баярсайхан/, Ерөнхий нягтлан бодогч /Н.Батбаяр/, Дотоод аудит, мониторингийн газрын дарга /Ц.Үүрцайх/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Б.АРИУНЖАРГАЛ  
Д.НОМИНГУА

9066109  
ATA16087  
9025081411



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1118/АД171254

Улаанбаатар хот

САГ-2026/16/НА-СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 36 байгууллагын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 31,331,786,530.00 /гучин нэгэн тэрбум гурван зуун гучин нэгэн сая долоон зуун наян зургаан мянга таван зуун гучин/ төгрөгийн 202 алдаа, зөрчил илэрснээс 12,257,136,900.00 /арван хоёр тэрбум хоёр зуун тавин долоон сая нэг зуун гучин зургаан мянга есөн зуун/ төгрөгийн алдааг залруулга хийлгэж, санхүүгийн тайлагналтай холбоотой 19,074,649,630.00 /арван есөн тэрбум далан дөрвөн сая зургаан зуун дөчин есөн мянга зургаан зуун гучин/ төгрөгийн 137 зөрчил илэрсэн нь төсвийн төвлөрүүлэн захирагчаас санхүү, нягтлан бодох бүртгэлд тавих дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-т "хариуцлагатай байх", 6.6.1-д "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх", 15.4-д "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:", 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй, зөрчлийг арилгах, алдаа зөрчлийг 20-оос доошгүй хувиар бууруулах арга хэмжээг авч, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Баярсайхан/, Ерөнхий нягтлан бодогч /Н.Батбаяр/, Дотоод аудит, мониторингийн газрын дарга /Ц.Үүрцайх/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Б.АРИУНЖАРГАЛ  
Д.НОМИНГУА

9006109  
ATA16087  
9025081411



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1119/А0171254

Улаанбаатар хот

САГ-2026/16/НА-СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудад нийцлийн аудиттай холбоотой нийт 20,093,899,000.00 /хорин тэрбум ерэн гурван сая найман зуун ерэн есөн мянган/ төгрөгийн 49 зөрчил илэрсэн. Үүнээс 17 байгууллагад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 18,550,775,700.00 /арван найман тэрбум таван зуун тавин сая долоон зуун далан таван мянга долоон зуун/ төгрөгийн зөрчил илэрснээс 7 байгууллагад зөрчил давтагдан гарсан нь Дотоод аудит, мониторингийн газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:", 6.4.3-т "тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.1-д "Төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх;", 15 дугаар зүйлийн 15.4-д "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:", 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;" гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулаагүй хугацаа хоцруулсан, зөрчлийг давтан гаргасан, дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах зөрчлийг 20-оос доошгүй хувиар бууруулах арга хэмжээг авч, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Баярсайхан/, Ерөнхий нягтлан бодогч /Н.Батбаяр/, Дотоод аудит, мониторингийн газрын дарга /Ц.Үүрцайх/ нарт даалгав.

**АЛБАН ЦААРДЛАГА ӨГСӨН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Б.АРИУНЖАРГАЛ  
Д.НОМИНГУА